



“Үр дүнд суурилсан удирдлага” -ын суурь ойлголт

Рэймонд Жирвэйс

2022

Агуулга

Энэ хэсэгт

- ❖ ҮДСУ-ийн суурь ойлголтоо **сэргээх**
- ❖ Монгол улсын холбогдох хууль, журмуудтай **холбон ойлгох**
- ❖ Бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглаж байгааг **тодорхой болгох.**

ҮДСУ гэж юу вэ?

- Үр дүнд суурилсан удирдлага (ҮДСУ) “гэдэг нь шийдвэр гаргах үйл явц, ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулахад чиглэсэн стратеги, боломж, үйл ажиллагаа болон түүнийг хэмжих арга барилыг нэгтгэсэн удирдлагын арга барил юм”

(Канадын Гадаад Хэргийн

Яам)

4.1.6. “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн **уялдааг хангасан** зорилго, зорилт, **хүрэх үр дүн, нөөцөд суурилан** боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

ҮДСУ нь доорхи зүйлд төвлөрнө

- ❖ Бодит үр дүн (үр нөлөө/зорилго)-г тодорхойлж, хэрэгжүүлэх
- ❖ Үр дүнтэй шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан явцыг хянах, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг тайлагнах хэмжилтийн системийг хэрэгжүүлэх
- ❖ Хүссэн үр дүнд хүрэхийн тулд болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох ба удирдах
- ❖ Сургамжуудыг нэгтгэх замаар байгууллагын шийдвэр гаргалтын үр дүн, оновчтой байдлыг сайжруулах

ҮДСУ-ын үр дүн гэж юу вэ?

- Үр дүн (эсвэл үр нөлөө) гэдэг нь
- ---**шалтгаан үр дагавраас** бий болж буй тодорхойлогдохуйц эсвэл хэмжигдэхүйц **өөрчлөлт**

“Хэрэв..., тэгвэл...”

Монгол Улсын холбогдох хуулийн:

4.1.18 заалтад : "**бодлогын үр нөлөө**" гэж бодлогыг хэрэгжүүлснээр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд бий болох эерэг өөрчлөлтийг;

ҮДСУ-н үнэ цэнэ бий болгодог зарим онцлог шинжүүд

- ❖ Хяналт-шинжилгээ, үнэлгээний систем нь урт хугацааны үр дүн болон өөрчлөлтөд төвлөрдөг...**үйл ажиллагаанд биш**
- ❖ ЗГ-ын үйл ажиллагааны ил тод байдал ба хариуцлагыг сайжруулахад хувь нэмэр болдог.
- ❖ Баталгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах; гэнэтийн эрсдэлийг удирдах боломж олгодог.
- ❖ Үйл ажиллагааны үр ашиг, үр дүнг ихэсгэдэг.
- ❖ Удирдлагад өөрийн байгууллагын өөрчлөлтийг илүү сайн удирдах боломж олгодог.
- ❖ Авсан сургамжууд нь удирдлагад тодорхой өөрчлөлт, сайжруулалт хийх боломж олгодог.
- ❖ Хяналт-шинжилгээ, үнэлгээний товч тодорхой, үр дүнд төвлөрсөн тайлан нь цаг хэмнэдэг.

ҮДСУ-ын арга хэрэгсэл

1. Бодит хүссэн ҮР ДҮНГ тодорхойлох...
Бидний хийж буй ажлын үр дүнд юуг өөр байлгахыг хүсэж байна вэ?
2. ОРОЛЦОГЧ ТАЛУУД болон тэдгээрийн сонирхлыг тодорхойлох
Манай үйлчлүүлэгч хэн бэ? Бидний ажлын үр шимийг хэн хүртдэг вэ?
3. Үр дүнгийн ГИНЖИН ХОЛБОО тогтоох
Манай нөөц, үйл ажиллагаа хүссэн үр дүнд хүргэх үү?
4. ЭРСДЭЛИЙГ тодорхойлох, удирдах нь
*Бидний ахиц амжилтад саад болох зүйл юу вэ?
Энэ эрсдэлийг бид хэрхэн бууруулах вэ?*

үргэлжлэл

5. Ахиц амжилтаа ХЯНАХ

Бид өөрсдийн байгаа нөөц бололцооны хүрээнд хүссэн үр дүндээ хүрч байна гэж хэрхэн дүгнэх вэ?

6. Гарсан үр дүн, зарцуулсан нөөцийг ТАЙЛАГНАХ

Манай хэлтсээс гадуур болж буй үйлдлийн талаар бид хэрхэн харилцан мэдээлэлтэй байх вэ?

7. СУРАЛЦСАН ЗҮЙЛЭЭ нэгтгэх

Байгууллагын шийдвэр гаргах, үр ашигтай, үр дүнтэй байдлыг сайжруулахын тулд цуглуулсан мэдээллийг бид хэрхэн ашиглах вэ?

ᠭᠢᠯᠠᠢᠯᠠᠭ᠎ᠠ

“Гялайлаа”





Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii
gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000